



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/102.

Мөрөн сум

**Хагас жилийн мал тооллого  
явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.В дэх заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Аймгийн Засаг даргын 2025 оны 05 сарын 28-ны өдрийн А/319 тоот захирамжийг тус тус үндэслэн захирамжлах нь :

1.Мөрөн сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 06 сарын 04 -өөс 2025 оны 06 сарын 10-ны хооронд явуулсугай.

2.2025 оны Хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

|                       |              |                                       |
|-----------------------|--------------|---------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Мягмаржав  | Засаг даргын Орлогч                   |
| Нарийн бичгийн дарга: | Г.Дашмаа     | Төрийн сангийн мэргэжилтэн            |
| Гишүүд:               | Ш.Баасандорж | Байгаль орчны Хяналтын Улсын байцаагч |

|                 |                                           |
|-----------------|-------------------------------------------|
| Ж.Алтанцэцэг    | Татварын Улсын байцаагч                   |
| С.Сүхчулуун     | Зөөлөн багийн Засаг дарга                 |
| Н.Амармөрөн     | Өлзийт багийн Засаг дарга                 |
| Т.Гүржав        | Бүрээт багийн Засаг дарга                 |
| Э.Балчиндорж    | Цагаантолгой багийн Засаг дарга           |
| Д.Золзаяа       | Чандган багийн Засаг дарга                |
| С.Энхсүх        | Соёл, сан хариуцсан нягтлан бодогч        |
| А.Энхтөр        | Аж ахуйн нярав                            |
| Г.Загдхорол     | Халамж үйлчилгээний мэргэжилтэн           |
| Д.Ганцэцэг      | Улсын бүртгэгч                            |
| Ц.Болорцэцэг    | Хоршоо, жижиг дунд хариуцсан мэргэжилтэн  |
| Б.Нандин-Эрдэнэ | Засаг даргын тамгын газрын Нягтлан бодогч |
| Ө.Өнөрөө        | Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан        |
| С.Оюунтулга     | Идэвхтэн байгаль хамгаалагч               |

3. Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, ажиллахыг Засаг даргын орлогч ( Б.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ХАТАНБААТАР